

Судалгааны Тойм

№7 | WWW.FORUM.MN | БОДЛОГЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ | СУДАЛГААНЫ САН | ВИДЕО

ХОРИХ ЯЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАСАХ АРГАЧЛАЛЫН ХЭРЭГЛЭЭ

ТОВЧ ТАЙЛБАР

2015 онд шинэчлэн баталсан Монгол Улсын Эрүүгийн хуулийн 1.9 дүгээр зүйлийн 1-д¹ “Үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцохгүй болсон, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хуулийг буцаан хэрэглэнэ”, мөн зүйлийн 3-т “Шинэ хуулиар тухайн гэмт хэрэгт оногдуулах ялын хэмжээг багасгасан тохиолдолд шүүх урьд ял шийтгүүлсэн этгээдийн ялыг шинээр тогтоосон хэмжээнд нийцүүлэн хасна” гэж тус тус заасан. Харин Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлд “2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө ял шийтгүүлсэн этгээдэд оногдуулсан ял нь 2015 оны 12 дугаар сарын 3-ны өдөр баталсан Эрүүгийн хуулийн зохих зүйл, хэсэгт зааснаар оногдуулж болох тухайн төрлийн ялын хэмжээнээс хүнд байвал уг ялыг шүүх дүйцүүлэн хасна” гэж хуульчилсан.

Бид дээрх заалтыг удирдлага болгон “Хорих ялыг дүйцүүлэн хасах аргачлал”-ыг математик статистикийн шинжлэх ухааны “шугаман регрессийн шинжилгээний арга”-ын тэгшитгэлийн үндсэн зарчим дээр тулгуурлан боловсруулсан болно.

Монгол Улсын дээд шүүхээс хорих ялыг дүйцүүлэн хасахдаа “ялын дундаж индексийг ашиглах”, эсхүл “ялын интервалаар хуульд нийцүүлэн хасах”, “математик статистикийн аргачлал” зэрэг арга, аргачлал, хувилбаруудыг харьцуулан судалж, нийт шүүгчийн хуралдаанаар 2017 оны 6 дугаар сард хэлэлцсэний үндсэн дээр энэхүү “математик статистикийн аргачлал”-ыг сонгон 2017 онд хэрэглэх шийдэлд хүрч, практикт хэрэглэсэн байдаг.

СУДАЛГААНЫ ДҮН

Нэг. Аргачлалын томьёо

X_1 - Хуучин Эрүүгийн хуулийн хорих ялын доод хэмжээ	Y_1 - Шинэ Эрүүгийн хуулийн хорих ялын доод хэмжээ
X_2 - Хуучин Эрүүгийн хуулийн хорих ялын дээд хэмжээ	Y_2 - Шинэ Эрүүгийн хуулийн хорих ялын дээд хэмжээ
$\Delta X = X_2 - X_1$ - Хуучин Эрүүгийн хуулийн хорих ялын интервал	$\Delta Y = Y_2 - Y_1$ - Шинэ Эрүүгийн хуулийн хорих ялын интервал

¹ Эрүүгийн хууль (Шинэчилсэн найруулга). “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2016. №07.

Дээрх хувьсагчаар илэрхийлсэн үзүүлэлтийг ашиглан өмнөх Эрүүгийн хуулийн хорих ялын нэгж хэмжээнд харгалзах, шинэ Эрүүгийн хуулийн хорих ялын хэмжээг илэрхийлэх коэффициентийг гаргана. Өөрөөр хэлбэл, хорих ял дүйцүүлэх коэффициентийг доорх томъёогоор бодно:

$$K = \frac{\Delta Y}{\Delta X} = \frac{Y_2 - Y_1}{X_2 - X_1} \quad (\text{Томъёо 1})$$

X^* - Тухайн ялтанд хуучин Эрүүгийн хуулиар оногдуулсан хорих ял

Y^* - Шинэ Эрүүгийн хуулиар буурах хорих ял.

Ялтны ялын хэмжээ шинэ Эрүүгийн хуулиар хэрхэн буурахыг тооцоолох нь хүсэж буй судалгааны үр дүн юм. Шинээр баталсан Эрүүгийн хуулиар хорих ялын хэмжээ хэрхэн буурахыг Томъёо 2-ыг ашиглаж бодно.

$$Y^* = Y_1 + K * (X^* - X_1) = Y_1 + \frac{Y_2 - Y_1}{X_2 - X_1} * (X^* - X_1)$$


(Томъёо 2)

Хорих ялын доод, дээд хэмжээ шинэ Эрүүгийн хуулиар өөрчлөгдсөн байх тул ялын хэмжээг бууруулахдаа Томъёо 2-ыг ашиглана. Математик статистикийн аргачлалаар хорих ялыг дүйцүүлэн хасахдаа жилээр тооцох бөгөөд сар, хоногоор тооцох тохиолдолд нэг жилийг 365 хоногт шилжүүлэн тооцох замаар тооцоолно. Дээрх үндсэн Томъёо 1, 2-ыг ялын дээд, доод хэмжээний өөрчлөлтөөс хамааран дөрвөн өөр хувилбараар ялыг дүйцүүлэн хасаж тооцно.

АРГАЧЛАЛЫГ ХЭРЭГЛЭСЭН БАЙДАЛ

Шинэ Эрүүгийн хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд 2017 оны 7 дугаар сард Эрүүгийн хуулийн тэгшитгэлд хамруулах ажлыг Улсын дээд шүүх (УДШ), Шүүхийн ерөнхий зөвлөл (ШЕЗ), Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар (ШШГЕГ)-аас зохион байгуулсан байна. ШЕЗ-ийн албан ёсны судалгаа, мэдээллээс үзэхэд анхан шатны шүүхүүдэд 25 хорих анги, 14 шийдвэр гүйцэтгэх албанаас 4,878 ялтны материал хүлээн авснаас 4,124 ялтны ялыг дүйцүүлэн хасжээ. Улсын хэмжээнд 4,124 ялтны хорих ялыг бидний боловсруулсан аргачлалын дагуу дүйцүүлэн хассанаар 1,050 ялтан суллагдаж 3,074 ялтны хорих ялыг дүйцүүлэн хассан нь² нийт ялтны 84.5 хувийг эзэлж байна.

Эрүүгийн хуулийн тэгшитгэлийн тоон мэдээлэл.³



² ШЕЗ-ийн Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн мэдээлэл

³ ШЕЗ-ийн Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс бидний боловсруулсан математик статистикийн аргачлалыг хялбаршуулах үүднээс хуучин болон шинэ Эрүүгийн хуулийн интервалыг 100 хэсэгт хуваан харгалзуулах байдлаар excel программ дээр томъёолол хийн шүүхүүдэд хүргүүлсэн нь хорих ялыг дүйцүүлэн хасах үед зарим шүүгч цаг хугацаа хэмнэсэн, хэрэглэхэд хялбар болсон гэж дүгнэж байв.

ШЕЗ-ийн мэдээллээр 4,124 ялтны ялыг дүйцүүлэн хассан гэх албан ёсны мэдээлэл байна. УДШ-ийн Эрүүгийн хэргийн танхимаас аймаг, нийслэлийн

шүүхүүдэд хорих ялыг хэрхэн дүйцүүлэн хасах, чөлөөлөх талаарх зөвлөмж, хууль буцаан хэрэглэх тухай захирамж боловсруулах аргачлал, үндсэн томъёог хүргүүлсэн. УДШ нь математик статистикийн энэ аргачлалыг Эрүүгийн хуулийн хууль ёс, шударга ёсны зарчимд илүүтэй нийцнэ хэмээн үзэж сонгожээ.

Ийнхүү хууль сахиулах, хэрэгжүүлэх ажиллагаанд математик статистикийн аргачлалыг хэрэглэсэн нь нийгмийн инновац (*Social innovation*) буюу хууль зүйн практикт шинэ хэрэглээг оруулж буйгаараа онцлог юм.

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

1. Эрүүгийн хууль буцаан хэрэглэх, ялангуяа хорих ялыг дүйцүүлэн, эсхүл нийцүүлэн хасах аргачлал шүүхийн практикт нэг мөр жишиг байдлаар тогтоогүй байна.

Зөвлөмж: Эрүүгийн хууль буцаан хэрэглэх, ялангуяа хорих ялыг дүйцүүлэн, эсхүл нийцүүлэн хасах аргачлалыг нэг мөр жишиг байдлаар хэрэглэдэг байх талаар Улсын дээд шүүхээс тайлбар гаргах, эсхүл Эрүүгийн хууль, түүнийг дагаж мөрдөх журмын тухай хуулиудын нийцлийг хангах, цаашид “ялыг дүйцүүлэн хасах” гэдгээр нэршиж хэвших, шаардлагатай бол Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал хүргүүлэх.

2. Хорих ялыг дүйцүүлэн хасах аргачлалыг анхан, давах, хяналтын шатны шүүх, шүүгч харилцан адилгүй ойлгож, хэрэглэж байна.

Зөвлөмж: Хорих ялыг дүйцүүлэн хасах аргачлалыг эрх бүхий байгууллага, албан тушаалтнуудын шийдвэрээр стандартчилан, Эрүүгийн хуулийг шинээр мөрдөх, өршөөл үзүүлэх үед нэг мөр шууд хэрэглэдэг байх.

3. Хорих ялыг дүйцүүлэн хасах аргачлалыг өршөөл үзүүлэх үед хэрэглэх асуудал ч тодорхой бус байна.

Зөвлөмж: Өршөөлийн хууль батлан хэрэгжүүлэх тохиолдолд энэ аргачлалыг

хэрэглэх асуудлыг авч үзэж, практикт хэрэглэх.

4. Эрүүгийн хуулийн үр дүнг тооцоход ШЕЗ, УДШ, ШШГЕГ-ын тоон мэдээлэл уялдаагүй, нэгдмэл байдал хангагдаагүй байна.

Зөвлөмж: ШЕЗ, УДШ, ШШГЕГ-ын тоон мэдээллийг уялдуулах, нэгдмэл байдлыг хангах.

5. Эрүүгийн хуулийн ерөнхий ангид хууль буцаан хэрэглэх талаар заасан зохицуулалтын хүрээнд түр хугацаанд нэмэлт, өөрчлөлт ороод хүчингүй болсон хэм хэмжээ, ялыг хэрхэн дүйцүүлэн бодохыг эцэслэн шийдэх шаардлагатай. Энэ асуудлыг одоогоор зохицуулсан хэм хэмжээ байхгүй бөгөөд онолын маргаантай асуудалд тооцогдож байна.

Зөвлөмж: Ялыг хэрхэн дүйцүүлэн бодохыг эцэслэн шийдэх

6. Хорих ялыг дүйцүүлэн хасах асуудлаар салбарын эрдэмтэн, судлаачдын сонирхол, судалгаа, оролцоо дутмаг явснаас энэ институц сул хөгжжээ.

Зөвлөмж: Ялыг дүйцүүлэн хасах асуудалд эрдэмтэн, судлаачдын анхаарлыг хандуулах, энэ институц судлалыг хөгжүүлэх.

